



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 0/38

Улаанбаатар хот

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 194,900,000.0 /нэг зуун ерэн дөрвөн сая есөн зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 2 тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ /Б.Цолмон/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ /Б.Цолмон/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 02 дугаар
сарын 11 өдрийн 01/38 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	Тоёота кроун 11-34 УНЛ	29,900,000.0	29,900,000.0	0.0
2		Камаз-43105 23-56 УНЦ	165,000,000.0	165,000,000.0	0.0
Дүн			194,900,000.0	194,900,000.0	0.0